



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 04 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

## Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.13-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуультай холбогдсон журам, заавар болон даатгалын гэрээ, гэрчилгээний загварыг 2002 оны 3 дугаар улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй хамтран боловсруулж батлан, бэлэн болгох;

2/ Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль нь иргэдийг хамарч үйлчлэх хүрээ өргөжиж, арга хэлбэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан уг хуулийг сурталчлах, даатгалын байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР